

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

1 дүгээр зүйл.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

“4/баталгаат тэтгэвэр”

2/8 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг:

“4.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д заасан өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн энэ хуулийн дагуу цэргийн алба хаасны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 2.1.8-д заасан баталгаат тэтгэвэр олгоно.

5.Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан тэтгэвэр авагчид баталгаат тэтгэвэр олгох харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн холбогдох заалтаар зохицуулна.”

4/9 дүгээр зүйлийн 5, 6, 7, 8 дахь хэсэг:

“5.Доор дурдсан нөхцөл хангасан баталгаат тэтгэвэр авагчийн нөхөр, эсхүл эхнэр нас барсан тохиолдолд эхнэр, эсхүл нөхрийн авч байгаа баталгаат тэтгэврийн хэмжээг 50 хувиар нэмэгдүүлэн олгоно:

- 1/Гэр бүлийн тухай хуулийн 7.1-д зааснаар бүртгүүлсэн;
- 2/15 ба түүнээс дээш жил хамт амьдарсан;
- 3/Нөхөр, эхнэр хоёулаа баталгаат тэтгэвэр авагч байх.

6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан баталгаат тэтгэврийн нэмэгдлийг тэтгэвэр авагчийн нас барсны дараагийн 2 дахь сараас эхлэн олгоно.

7.Энэ хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагч ажил олгогч, хүнтэй хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа тохиолдолд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан насанд хүртэл Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.4-т заасан нийгмийн даатгалын төрөлд албан журмаар даатгуулна.

8.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.2-т заасан насанд хүрсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан тэтгэвэр авагч Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг